

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 12

- “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын
1. тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр
өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

7 – 12

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын
12 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн хамтарсан
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 55 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 50.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 51 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: П.Ганчимэг, Г.Ганбаатар, С.Ганбаатар, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Туваан, А.Ундраа;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Д.Жаргалсайхан, М.Мандхай, У.Отгонбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Уянга;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Д.Батбаяр, Р.Батболд, Х.Болормаа, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, П.Ганзориг, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, Ч.Номин, Б.Түвшин.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Төрмөнх нар байлцав.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу уг асуудлыг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулав. /12.13/

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хамтарсан хуралдаан 23 минут үргэлжилж, 55 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 50.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 14 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 51 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Үүрийнтуяа: Байнгын хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын гишүүдийн олонх ирж ирц 50.9 хувь бүрдсэн тул 2025 оны 12 сарын 02-ны өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Төсвийн байнгын хорооны хуралдаанд ирсэн гишүүд.

Норовын Алтанхуяг 11 дүгээр тойрог, Тилеуханы Аубакир 3 дугаар тойрог, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог, Жадамбын Батсуурь жагсаалт, Жамбалын Ганбаатар 9 дүгээр тойрог, Цэрэнпилийн Даваасүрэн 4 дүгээр тойрог, Пүрэвжавын Сайнзориг 11 дүгээр тойрог, Баатаржавын Мөнхсоёл жагсаалт, Пүрэвбаатарын Мөнхтулга 1 дүгээр тойрог, Загджавын Мэндсайхан 2 дугаар тойрог, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог, Даваахүүгийн Пүрэвдаваа жагсаалт, Ганзоригийн Тэмүүлэн 1 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа 4 дүгээр тойрог, Даваагийн Цогтбаатар 1 дүгээр тойрог, Дашцэрэнгийн Энхтүвшин жагсаалт.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд ирсэн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Буланы Бейсен 3 дугаар тойрог, Наранцэцэгийн Алтаншагай 11 дүгээр тойрог, Очирбатын Амгаланбаатар 2 дугаар тойрог, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог, Мөнгөнцогийн Ганхүлэг 6 дугаар тойрог, Хассуурийн Ганхуяг 9 дүгээр тойрог, Сонгобайн Замира жагсаалт, Жаргалсайханы Золжаргал 9 дүгээр тойрог, Цагаанхүүгийн Идэрбат 6 дугаар тойрог, Тогтмолын Мөнхсайхан 12 дугаар тойрог, Баатаржавын Мөнхсоёл жагсаалт, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог, Салдангийн Одонтуяа жагсаалт, Жигжидийн Чинбүрэн 8 дугаар тойрог.

Байнгын хорооны хамтарсан хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд танилцуулна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Ц.Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Энэ оны төгсгөл болох гэж байна.

Тийм учраас ялангуяа Төсвийн байнгын хороо, манай Их Хурал төсөв эдийн засгийн гүйцэтгэлийн талаар нэг ярихгүй бол болохгүй болчхоод байна.

Хуучин намрын чуулганаар хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, төсвийн гүйцэтгэл, мөнгөний бодлогыг маш сайн ярьдаг байсан. Одоо ярихаа больсон байна.

Гэтэл яг эдийн засгийн байдал чинь хүндэрчхээд байна. Төсвийн санхүүжилт ерөөсөө зөвхөн цалин олгож байна шүү дээ. Гэтэл 10 сарын гүйцэтгэлээр харахаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад экспортын орлого чинь 1 тэрбум доллароор тасарсан байна. Тэр дотроо нүүрс 3 тэрбум доллароор тасарсан байна.

Энэ чинь эргээд төсөвтөө хүндрэл учруулаад 10 сарын гүйцэтгэлээр төсвийн орлогын биелэлт чинь муудаад, алдагдал нь 3.1 их наяд төгрөг болсон байна. Ингээд яваад байж болохгүй. Энэ чинь эргээд ирэх хавар хүндрэл учруулахын дохио.

Ер нь яах вэ ингээд Их Хурал хэтэрхий залуужсандаа байна уу? Ийм зүйлүүдийг ярихаа больсон байна. Хуучин ярьдаг байсан.

Тэгээд энэ ажил амьдралын туршлагагүй байна гэдэг чинь байна шүү дээ ирээдүйд учрах зовлон бэрхшээлийг төсөөлдөггүй юм байна. Тэгж боддоггүй юм байна. Өнөөдрөөрөө амьдардаг юм байна.

Тэгээд хараад байхад тодрох гэдэг нэг өвчтэй. Тэгээд нэг попорсон юм ярьчихаад л, тэгээд л түүндээ сэтгэл ханаад л байж байна шүү дээ. Улс орон энэ төр удирдахад оролцож байна гэдгээ ерөөсөө бодохгүй байгаад байна.

Тийм учраас хэдүүлээ жоохон амьдралд наалдацгүй юм ярьдгаа болиод эдийн засгийн байдалдаа анхаарахгүй энэ чинь бид нарыг хавар сүйтгэж мэднэ. Өнөөдөр ийм болчхоод байгаа юм чинь ирэх жил яах вэ гэдгээ бид одоо ярьж явах ёстой шүү дээ.

Тийм учраас би Төсвийн байнгын хороо өнөөдрийн хуралдаанаараа эдийн засгийн гүйцэтгэлээ нэг ярь. Тэгэхгүй бол энэ валютын ханш чинь ер нь маш хүнд байдал руу орно.

2022 онтой харьцуулахад мөнгөний нийлүүлэлт. Тэр үед 30 их наяд байсан бол одоо 45 их наяд болчихсон байгаа. 50 дахин өссөн байна шүү дээ.

Тэгэхээр бид валютыг алдах юм бол яах вэ. Валютын ханш чинь 5 мянган төгрөгийг давах гээд байна гэсэн үг. Энэ мөнгөний нийлүүлэлт чинь. 1 долларт оногдох мөнгө чинь өсчихсөн байна. Ингээд урсгалаараа яваад байх юм бол маш хүнд байдал руу ороод, тэгээд нөгөө төсвөө тодотгоно гээд өнгөрсөн борооны оны цув нөмөрнө гэдэг шиг хашхираад эхэлнэ шүү дээ.

Тэгээд хэдүүлээ гүйцэтгэлээ маш сайн яриад, гүйцэтгэл дээр учирч байгаа хүндрэлүүдээ яриад, тэгээд ирэх жилээ яах вэ гэдэг юмнуудаа бас нэг жоохон төсөөлж аваад шинэ онтой золгомоор байна.

Одоо томилолт ярьдгаа жоохон багасгаад, эдийн засгийн гүйцэтгэлээ ярь. Оны төгсгөл болчхоод байна.

Тийм учраас Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Сангийн сайдын мэдээллийг сонсьё. Юунаас болж юу тасраад яагаад байна вэ, төсөвт яагаад хүндрэл учраад байна вэ гэдэг юмнуудаа ярихгүй бол болохгүй.

Яагаад гэвэл миний харж байгаагаар яг 2000 оны эхэн үе 90-ээд оны төгсгөл үеийнх нь байдал руу санхүүжилтийн нөхцөл байдал чинь ороод байна шүү дээ. Маш хүндрээд байна шүү дээ.

Ялангуяа төсөв чинь гурав дахин өссөн үед энэ бол шокийн байдалд оруулна шүү. 2021 онтой харьцуулахад гурав дахин өсчихсөн. 10 их наядыг зовж санхүүжүүлдэг байсан бол одоо 30 их наядыг зовж санхүүжүүлэх тухай яриад байна шүү дээ. Энэ чинь бид нарыг сүйрэлд авчирна. Энэ өсөлт чинь. Өнөөдөр эд нарыгаа ярьж ирэх жилийнхээ тухай хэдүүлээ анхаарч төсвөө эхнээс нь тодотгоод явах юм уу, яах юм гэдэг юмнуудаа ярихгүй бол болохгүй болжээ.

Тэгэхээр өнөөдрийн хуралдааны энэ үеэрээ бид мэдээлэл сонсьё. Сангийн сайдын.

Д.Үүрийнтуяа: Ц.Даваасүрэн гишүүнтэй гүйцэтгэлийг сайн сонсож, төсөв санхүү, эдийн засгийн нөхцөл байдлыг сонсох ёстой гэдэгтэй санал нэг байна.

Өнөөдрийн хуралдаан бол Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаан эхэлж байна.

Үүний дараа Төсвийн байнгын хороо дангаараа хуралдана. Мөн даргын дэргэдэх зөвлөл дээр бид хэлэлцэх асуудлын тов дарааллыг оруулж хэлэлцэх асуудлаа тухайн долоо хоногтоо батлуулж байгааг Та хамгийн сайн мэдэж байгаа.

Тэгээд таны гаргасан саналын дагуу даргын дэргэдэх зөвлөлд Сангийн сайдын болон Монголбанкны мэдээллийг Эдийн засгийн байнгын хороотой хамтарч сонсох саналыг хүргүүлье.

Өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Өнөөдөр урьдчилж зарлаагүй учраас өнөөдөр шууд сонсоно гэж хэлж чадахгүй нь л дээ.

Саналтай гишүүн байхгүй байна. /алх цохив/

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг хуралдаанд оруулъя.

Албан тушаалтнуудыг танилцуулъя.

Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

“Тогтоолд нэмэлт оруулах” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Би нэг асуулттай байна. Надад энэ тогтоолтой холбоотой нэг тодруулах зайлшгүй шаардлагатай зүйл байгаад байна.

Уг нь Монгол Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ тогтоолын төслийг боловсруулахдаа Та бүхэн хууль тогтоомжийг боловсруулах арга, аргачлал, хууль тогтоомжийн тухай хуульд заасан 30.1.3-д заасан үндсэн шаардлагуудыг хангаж боловсруулах ёстой. Хоёрдмол агуулгагүй, ойлгомжтой байх ёстой гэдэг зүйл, заалт дээр надад үүнийг хангаж байна уу, үгүй юу гэдэг ийм эргэлзээ төрөөд байна.

Энэ тогтоолын төсөлд орж ирсэн Засгийн газарт хувь хэмжээ тогтоох эрх шилжүүлж байгаа тодорхой заалтууд байна. Энэ дээр 11.01 гэж Их Хурлын тогтоолын төсөлд орж ирсэн боловч яг тэр тогтоолын төсөлд заасан дүнгээр нь аваачаад тогтоолд нь суулгаад харахаар 11.01, 11.02 хоёр хоёулаа орж харагдаж байгаа.

Өөрөөр хэлбэл –

- 11.01 нь улаан буудай болон хөх тарианы гурил,
- 11.02 нь улаан буудай, хөх тарианы гурилаас бусад төрлийн үр тарианы гурил.

Тэгээд Хүнс, хөдөө аж ахуйн яам тайлбарлахдаа 11.02 буюу хөх тарианы гурил, улаан буудай. Хөх тарианы гурилаас бусад гурилын татварыг өөрчлөх эрхийг Засгийн газарт олгоогүй. Зөвхөн улаан буудайн болон хөх тарианы гурилын татвар дээр өөрчлөлт оруулах эрхийг олгож байгаа юм гэдэг зүйл яриад байдаг.

Гэтэл яг Улсын Их Хурлын тогтоолын төслийг тогтоол дээр нь суулгаад харахаар 11.01, 11.02 чинь хоёулаа орж харагдаад байна. Тэгээд хоёрдмол агуулгыг хэрэглэх боломжтой болж харагдаад байна л даа. Энэ дээр ер нь ямар байр суурьтай байгаа юм бэ? Энэ дээр тодорхой хариулт өгөөч.

5 номерын микрофоныг өгье.

Д.Есөн-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ.

Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулья.

Өргөн бариад хэлэлцэгдэж байгаа тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр заалтад гаалийн албан татварын хувь хэмжээг Засгийн газарт тогтоохоор ийм эрх олгосон заалт байгаа.

Тогтоолын төсөлд зөвхөн 11.01 багтаж байгаа. 11.02 хөндөгдөөгүй.

Тэгэхээр 11.01-ийг бид нар үндэслээд. 11.01 гэдэг нь улаан буудайн гурил, улаан буудай, хөх тарианы гурил гэсэн ийм бүтээгдэхүүн байгаа.

Тэгэхээр энэ дээрээ Засгийн газрын дахиад тогтоол гарна. Засгийн газрын тогтоол дээрээ БТКУС_[Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Систем] кодуудыг бичээд нэг мөр ойлголцохоор Засгийн газрын тогтоолдоо тусгаад явна.

Тэгэхээр 11.02 гэдэг бусад хөх тарианаас бусад гурил буюу бусад үр тарианы гурилуудыг, тухайлбал эрдэнэ шишийн гурилууд гэж ойлгогдож болно.

Д.Үүрийнтуяа: Хэдүүлээ яах вэ, амаараа яриад ойлголцоод байж болоод байгаа юм.

Албажаад гараад ирэхээр тогтоол дээр чинь зөрүү үүсэх гээд байна шүү дээ.

Та бүхний өмнө нь батлуулж өөрчлүүлсэн энэ тогтоолын төсөлд –

- 2000 оны 11 сарын 17-ны өдөр 51 дүгээр тогтоол,
- 2021 оны 90 дүгээр тогтоол,
- 2002 оны 44 дүгээр тогтоолд тус тус өөрчлөлт оруулаад –

-11.01 болон 11.02 хоёрыг нэг хүснэгтэд Та нар аваачиж хийсэн.

Тэгэхээр нэг хүснэгтэд буюу нэг мөрөнд аваачаад хийхээр яг өнөөдөр хэрэгжиж байгаа хүчин төгөлдөр тогтоол чинь 11.01 болон 11.02 буюу бүх төрлийн гурил дээр 5, 15 гэсэн хувьтай явж байгаа.

Гэтэл энэ дээр ямар өөрчлөлт орж байна гэдэг дээр 5 хүртэл, 15 хүртэл. 11.01, 11.02 ямар ч өөрчлөлтгүй.

Энэ нь эргээд юу гэж харагдаж байна гэхээр яг энэ нэмэлт, өөрчлөлтийг тусгаад өнөөдөр юу гэдэг юм 2025 оны 12 сард орсон нэмэлт, өөрчлөлтөөр гэхээр “хүртэл” гэдэг хоёр үг нэмэгдэж байгаа болохоос биш 11.01 11.02 хоёр дээр өөрчлөгдөөгүй байгаа.

Би асуултаа асууж байна. Гишүүнийхээ хувьд.

Тийм учраас энэ заалтыг тодорхой гаргаж өгөөч ээ гэж байгаа юм. Тодорхой гаргаж өгөөч ээ.

Яагаад гэхээр хэрвээ 11.01 11.02 хоёр өөрчлөгдөх юм бол энэ дээр асуудал үүсэх гээд байна. Энэ дээр юу гэж үзэж байгаа юм бэ? Хүнс, хөдөө аж ахуйн яам.

5 номерын микрофоныг өгье.

Д.Есөн-Эрдэнэ: Гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье.

Тогтоолын төслийг боловсруулж байхад Гаалийн ерөнхий газар болон Сангийн яамны холбогдох мэргэжилтэн, газрын дарга нар оролцсон. Энэ дээр ярилцсан.

Энэ дээр ярилцах үед зөвхөн эрх олгож байгаа тогтоолоор 11.01 нь л хөндөгдөж байгаа. 11.02 хөндөгдөхгүй байгаа гэж ойлгогдохоор байгаа. Цаашдаа Сангийн яамнаас Улсын Их Хурлын тогтоолын бичвэр болон мөрийг өөрчлөх, ойлгомжтой байдлаар ажиллах болно гэдгийг ажлын хэсэг дээр ярилцаж байсан гэдгийг Та бүхэнд дуулгая.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авлаа. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу?

Тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцэж байгаа учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасан хугацаа хамаарахгүй. Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Энэ чинь Засгийн газраас оруулж ирсэн тогтоол байгаа юм л даа. Уг нь.

Тэгээд ялангуяа эрх шилжүүлэх гэдэг асуудал нэлээн сайн ярих ёстой зүйлүүд байгаа юм. Их Хурлын.

Татварын асуудал бол ер нь Их Хурлын онцгой бүрэн эрхэд байдаг эд.

Хоёрдугаарт, энэ тогтоолын асуудал хэлэлцэж байхад тэгээд бид нар яг хуулиараа сайд л хариулах ёстой байгаа юм л даа. Хуулиараа тийм юм. Уг нь.

Сүүлийн үед хараад байхад ерөөсөө нэг газрын дарга л ирдэг болсон. Бид өөрсдөө шаардах ёстой байхгүй юу. Тэгээд энэ нь ингээд бүр хэвшил болоод, тэгээд нэг газрын дарга орж ирээд хариулсан болоод л өнгөрдөг. Гишүүд нь ч

асуухаа больсон, гишүүд нь ч анхаарч хайхрахаа больсон. Тэгээд ямар тогтоол гарч байгаагаа, ямар үр дагавар авчрахаа ч гэсэн сайн ярихгүй. Ингээд байгаад байж болохгүй ээ.

Тийм учраас зарчмын зөрүүтэй санал гаргахынхаа өмнө сайдыг нь оролцуул. Тэгж байж хэдүүлээ ярилцаж байж энэ асуудлыг шийдье.

Д.Үүрийнтуяа: 5 номер. Сайд ямар асуудалтай, ямар ажилтай болоод оролцоогүй талаар чам төлөөлж байгаагийн хувьд Та тайлбар өг дөө.

Д.Есөн-Эрдэнэ: Ц.Даваасүрэн гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Италид хийх айлчлалын бүрэлдэхүүнд ажиллаж байгаатай холбоотойгоор энэ хуралд оролцоогүй болно.

Д.Үүрийнтуяа: Ц.Даваасүрэн дарга тодруулъя.

Ц.Даваасүрэн: Засгийн газрын тогтоолоор аль нэг сайд байхгүй байхад нэг сайд нь орлон гүйцэтгэхээр шийдвэрлэсэн байгаа.

Тэгэхээр Хөдөө аж ахуйн сайд байхгүй байгаа болбол аль нэг сайд ирэх ёстой шүү дээ. Тэгээд тэр сайд чинь хэн юм бэ?

Тэгээд энэ чинь Засгийн газраас орж ирсэн тогтоол юм байна шүү дээ. Тэгээд энэ ажил чинь чухал ажил юм уу, чухал биш ажил зүгээр ингээд нэг ёс төдий юм оромдоод өнгөрөх гээд байгаа юм уу?

Д.Үүрийнтуяа: Хариулъя. 5 номер.

Албан ёсоор томилогдсон, шийдвэр гарсан зүйл байгаа юу?

Д.Есөн-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдыг эзгүйд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд харилцан орлоод ингээд явдаг.

Энэ тогтоол нь чухал. Улсын Их Хурлын 64 нэр бүхий гишүүд санаачилж Засгийн газарт албан бичиг өгөгдсөний үндсэн дээр Засгийн газраас боловсруулан яаралтай горимоор Улсын Их Хуралд өргөн барьсан.

Д.Үүрийнтуяа: Ойлгомжтой. Зарчмын зөрүүтэй нэг санал орж ирсэн.

Өнөөдөр Ц.Даваасүрэн гишүүний тавьж байгаа асуудал нь хуулийн дагуу сайд оролцох ёстой юу гэвэл оролцох ёстой.

Гэхдээ өнөөдөр дэд сайд хуулиараа бид хориглоогүй, дэд сайдгүй байхаар шийдвэр гаргаагүй хэр нь өнөөдрийг хүртэл зөвхөн сайд ажиллаж байгаа. Энэ нь бас гадаад томилолттой байгаа нөхцөлд, сайд нар давхар ажилтай байгаа нөхцөлд асуудал үүсэж байгаа. Олон Байнгын хороон дээр гарч байгаа. Зөвхөн өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан биш маш олон байнгын хороон дээр ийм асуудлууд гарч байсан.

Тэгээд өнөөдөр бид нар төлөвлөсөн ажлаа ямар ч байсан бүтэн цаг 30 минут бараг хүлээж энэ Байнгын хороогоо эхлүүлсний хувьд хэлэлцээд явах зүйтэй байх.

Байнгын хороодын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирүүлээгүй.

Хамтарсан хоёр Байнгын хороо хуралдаж байгаа. Миний зүгээс болон Б.Бейсен гишүүний зүгээс тогтоолын төслийг хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс хоёр зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа.

Энэ хоёр зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Байнгын хорооны гишүүдийг танхимдаа цуглахыг хүсье. Санал хураалт явах учраас танхимдаа цуглахыг хүсье.

Төрийн нарийн бичиг яасан билээ?

Д.Есөн-Эрдэнэ: Төрийн нарийн бичгийн дарга бас өөр ажилтай.

Д.Үүрийнтуяа: Ямар ажилтай байгаа юм?

Д.Есөн-Эрдэнэ: Уулзалттай байгаа юм.

Д.Үүрийнтуяа: Тэгвэл Төрийн нарийн бичгийн даргыг ирэх хүртэл хугацаагаар хурлыг хойшлууллаа. /алх цохив/

Төсвийн байнгын хорооны хурлыг дангаар нь эхлүүлье. Төсвийн байнгын хороо дангаараа хуралдах ёстой. Ирцийг үүсгэе.

Хамтарсан хуралдаан 23 минут үргэлжилж, 12 цаг 14 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД